



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 1/30

Улаанбаатар хот

Үндэсний болон орчин үеийн
спортын төрлүүдийг сурталчлах
өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 375 жилийн ойд зориулсан Үндэсний спортыг сурталчлах өдөрлөг “Эрхий мэргэн” морин харвааны тэмцээнийг 2014 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Хан-Уул дүүргийн 14-р хороо Өлзийт хороолол дахь “Хан Монгол” морьтны холбооны Морин спорт сургалтын төвд зохион байгуулсугай.

2. Морин харвааны тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Морин харвааны тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2.020.000 /хоёр сая хорин мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үндсэн төсвийн биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Морин харвааны тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500086

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2014 оны ...*дугаар*... сарын *25*-ны өдрийн
...*дугаар* тушаалын хавсралт

Үндэсний болон орчин үеийн спортын
төрлүүдийг сурталчлах өдөрлөгийн төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 3 x 60.000 төг = 180.000 төг 3 x 50.000 төг = 150.000 төг 3 x 40.000 төг = 120.000 төг Тусгай шагнал 30.000	480.000
2.	Байгууллагын шагнал:	400.000
3.	Шүүгчдийн ажлын хөлс: /10 хүн x 2 өдөр x 20.000 төг/	400.000
4.	Тээврийн зардал	100.000
5.	Өргөмжлөл, цом	300.000
6.	Хөтлөгч, урлагийн тоглолт	340.000
ДҮН:		2.020.000

Боловсруулсан: Ахлах мэргэжилтэн
Хянасан: Нягтлан бодогч

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг